

ӨРХИЙН АМ БҮЛИЙН БҮТЦИЙН ЗАСВАРЛАЛТ: ТЭНЦВЭРЖҮҮЛЭХ ХЭМЖЭЭС

*Цэрэннадмидын Амартүвшин, Эдийн засгийн ухааны магистр, багш,
Хүн ам зүйн тэнхим, Эдийн Засгийн Сургууль, Монгол Улсын Их Сургууль*

Людовико Карраро, Эдийн засагч, Олон улсын зөвлөх

Мартин Кумпа, Эдийн засагч, Олон улсын зөвлөх

УДИРТГАЛ

Нэг хүнд ноогдох хэрэглээ гэсэн үзүүлэлт нь ядуурлыг тооцох, зорилтот бүлгүүдийг тодорхойлох зорилгоор олон оронд хэрэглэгддэг. Өрхийн нийт хэрэглээг өрхийн ам бүлийн тоонд хуваасан харьцаагаар дээрх үзүүлэлтийг тооцдог бөгөөд дундаж түвшингийн тооцоонуудыг хийхэд энэ үзүүлэлтийг хэрэглэх нь үндэслэлтэй, бодитой байх боломж сайтай байдаг. Гэсэн хэдий ч нэг хүнд ноогдох хэрэглээ гэсэн энэхүү үзүүлэлт нь ам бүлийн тооноос хамааран амьжиргааны түвшинг бодит байдлаас зөрүүтэй тооцох хандлагатай байдаг. Өөрөөр хэлбэл цөөн ам бүлтэй өрхийн хувьд амьжиргааны түвшинг бодит байдалтай харьцуулахад сайн байгаа мэтээр, харин ам бүл олонтой өрхийн хувьд бодит байдлаас нь доогуур үнэлэх гэх мэт.

Дээрх гажуудал бий болдгийн үндсэн шалтгаан нь нэг хүнд ноогдох хэрэглээг үндэслэн тооцоо хийх энэхүү аргачлал нь өөрөө өрхийн гишүүн бүр ижил төстэй хэрэгцээтэй байдаг, өрх дотор эдийн засгийн ялгаатай хэмжүүр байхгүй гэсэн таамаглал дээр үндэслэгддэгт оршино. Харин бодит амьдрал дээр өрхийн гишүүн бүр ижил хэрэгцээтэй байдаггүй. Насанд хүрсэн хүмүүс хүүхдүүдийг бодвол илүү хэрэглээтэй байдаг, түүнчлэн зарим зардлын хэмжээ өрхийн ам бүлийн тоотой шууд пропорционалиар өсөөд байдаггүй. Өрхийн ам бүлийн гишүүдийн хоорондох ижил биш хэрэгцээ болон эдийн засгийн ялгаатай байдлыг тусгаж тодорхой засварлалт хийх арга зүй байж болох бөгөөд энэ нь Тэнцвэржүүлэх хэмжээс

“equivalence scale” гэж томъёологдсон хэмжигдэхүүнийг ашиглах явдал юм. Өөрөөр хэлбэл, тэнцвэржүүлэх хэмжээсийг ашиглан жишсэн дундаж нэг хүнд ноогдох хэрэглээ гэсэн үзүүлэлтийг тодорхойлсноор дээр дурьдсан гажуудлыг багасгах боломжтой гэсэн үг.

Тэнцвэржүүлэх хэмжээс нь өрхийн аж байдалд үзүүлж байгаа хэрэглээний нөлөөлөл дээр түшиглэн тооцогддог. Түүнчлэн хэрэглээ ч мөн аж байдлын түвшингээс шалтгаалдаг гэдгийг юуны өмнө ойлгох нь маш чухал. Энэ нь анхаарах ёстой зүйл мөн боловч хөгшин настай хүнтэй болон хүүхэд бүхий өрхүүдийн амьжиргааны дундаж түвшинг тогтоох зорилгоор тэнцвэржүүлэх хэмжээсийг хэрэглэх нь нэг хүнд ноогдох хэрэглээг хэрэглэснээс илүүтэйгээр бодит байдалтай ойр тооцоог бий болгодог.

Монгол Улсад хэрэглэгдэх боломжтой тэнцвэржүүлэх хэмжээсийн тооцоог 2 аргачлалаар хийн энд танилцуулж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүн амын хувьд хэрэглэгдэх тэнцвэржүүлэх хэмжээсийн тухай мөн оруулав. Үндэсний Статистикийн хорооноос зохион байгуулан явуулдаг Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа (ӨНЭЗС)-ны 2012 оны мэдээллийн баазыг ашиглан тэнцвэржүүлэх хэмжээсийн тооцоонуудыг хийсэн болно.

1. ХЭРЭГЛЭЭНИЙ ТӨЛВӨӨР ТООЦОХ АРГАЧЛАЛ

Энэ арга зүй нь тэнцвэржүүлэх хэмжээс (ТХ)-ийг хүн амын бодит хэрэглээний төлөв дээр үндэслэн тооцох арга юм. Энэхүү арга

зүйгээр өрхийн хэрэглээний янз бүрийн бүрэлдэхүүн хэсгийг нэг хүнд ноогдох хэмжээсд шилжүүлэхэд үндсэн 2 бэрхшээл тулгардаг. *Нэгдүгээрт*, хэрэглээний ямар бүрэлдэхүүн хэсгүүд нь ам бүлийн гишүүн бүрээр тараагдаж болох ямар нь зөвхөн хамтарч хэрэглэж болох. *Хоёрдугаарт*, ямар хэрэглээ нь өрхийн насанд хүрсэн эхний хүнд хамаатай байж болох, ямар хэрэглээ нь бусад насанд хүрсэн хүнд хамаатай байж болох, ямар хэрэглээ нь мөн хүүхдэд хамаатай байж болох.

Эхний шатны тооцоолол

Түүвэр судалгаануудаар цуглуулагддаг хэрэглээний талаарх мэдээлэл нь хувь хүний түвшинд биш, өрхийн түвшинд байдгаас шалтгаалан дээрх бэрхшээл бий болдог.

Үүнтэй уялдуулан эхний ээлжинд өрхийн нийт хэрэглээг 2 үндсэн бүлэгт (нийтийн хэрэглээ болон хувийн хэрэглээ) хуваав. Нийтийн хэрэглээ гэдэгт өрхийн гишүүн бүр хамтран хэрэглэх боломжтой хэрэглээг оруулсан. Харин өрхийн хэн нэгэн гишүүн хэрэглэсэн байхад өөр нөгөө гишүүн нь хэрэглэх боломжгүй зүйлсийг хувийн хэрэглээнд оруулсан.

Удаан эдэлгээт зүйлс, сууцны түрээс, сууцтай холбоотой үйлчилгээний зардлууд болон халаалт нь нийтийн хэрэглээ юм. Хүнс, хувцас, тээвэр холбоо, боловсрол, эрүүл мэндтэй холбоотой зардлуудыг хувийн хэрэглээ гэж үзэж болно. Хүн амын тодорхой бүлгүүдээр хувийн болон нийтийн хэрэглээний хуваарилалтыг *Хүснэгт 1-т* харуулав.

Хүснэгт 1: Хувийн болон нийтийн хэрэглээ, хувиар, 2012

Нийт	Хэрэглээний эрэмбээр доод 40%-д байгаа өрхүүд	Хэрэглээний эрэмбээр доод 30%-д байгаа өрхүүд	Хэрэглээний эрэмбээр доод 20%-д байгаа өрхүүд	Хэрэглээний эрэмбээр доод 10%-д байгаа өрхүүд	Хэрэглээний эрэмбээр доод 5%-д байгаа өрхүүд
Бүгд	100	100	100	100	100
Хувийн	84	85	85	84	84
Хүнс	34	46	47	49	49
Хувцас	17	16	15	15	14
Тээвэр, холбоо	13	9	8	7	7
Архи, тамхи	1	2	2	2	1
Боловсрол	5	4	4	4	4
Эрүүл мэнд	5	2	2	2	1
Бусад	8	7	7	7	7
Нийтийн	16	15	15	16	16

Нийгмийн халамжийн тусламж үйлчилгээ нь амьжиргааны түвшин хамгийн муу байгаа өрхүүдэд зориулагдах ёстой гэдгийг бодолцвол хэрэглээний хуваарилалтын дээрх хувь хэмжээ эдгээр өрхүүдийн хувьд ямар байгааг шалгаж үзэх нь чухал. Тэнцвэржүүлэх хэмжээс нь хүн амын аль бүлэг зорилтот бүлэг байх вэ гэдгээс шалтгаалан өөр өөрөөр тооцогдох боломжтой. Гэхдээ *Хүснэгт 1-ээс* харахад хэрэглээний хуваарилалт хэрэглээний

эрэмбийн доод хэсэгт байгаа өрхүүдийн хувьд төдийлөн их ялгаатай биш байна.

2 дахь шатны тооцоолол

Дараагийн ээлжинд хэрэглээ нь өрхийн доторх ам бүлд хэрхэн тархаагдах вэ гэдгийг тооцох явдал юм. Өөрөөр хэлбэл, өрхийн ам бүлийн эхний хүн хэрэглээний хэдэн хувийг, ам бүлийн дараагийн гишүүд хэдэн хувийг, мөн

хүүхэд хэдэн хувийг хэрэглэсэн байж болох гэдгийг ойролцоогоор тооцоолно гэсэн үг. Хэрэглээний бүрэлдэхүүн хэсэг бүр харилцан адилгүй тархаагдсан болно.

Хүнс: ЭМЯ-аас тодорхойлсон хүнсний зүйлээс авах илчлэгийн нормын дагуу үүнийг тооцоолсон. 15 хүртэлх насны хүүхэд дунджаар 15 ба түүнээс дээш настай хүнд шаардлагатай нийт илчлэгийн 77%-ийг авсан байх.

Хувцас: ӨНЭЗС нь энэ бүрэлдэхүүн хэсгийн мэдээллийг эрэгтэй, эмэгтэй хүн болон хүүхэд гэсэн ялгаатай байдлаар цуглуулсан байсан. Энэ мэдээллийг үндэслэн харилцан ялгаатай өрхүүдийн хувьд тооцоог хийхэд өрхийн насанд хүрсэн хүний хэрэглээ хүүхэдтэй харьцуулахад 2 дахин их байна.

Тээвэр холбоо: Хэрэглээний нэр төрөл бүрээр нарийвчилсан шинжилгээг хийхэд хүүхэд насанд хүрсэн хүний хэрэглээний ¼-ийг хэрэглэдэг гэсэн тооцоо гарсан.

Архи, тамхи: Өрхийн зөвхөн насанд хүрсэн гишүүдийн хувьд ижил хувьтай байхаар тооцогдсон.

Боловсрол: Хүүхдийн хэрэглээ насанд хүрсэн хүний хэрэглээний 72% байна. Мэргэжлийн боловсролтой харьцуулахад суурь болон дунд боловсролын зардал бага байгаа. Өрхийн насанд хүрсэн хүн бүр адил хуваарилалттай.

Эрүүл мэнд: Хүүхэд насанд хүрсэн хүний хэрэглээний 25%-тай тэнцэх хэрэглээтэй байна. Бусад хувийн хэрэглээ: Өрхийн гишүүдийн дунд тэнцүү хэмжээтэйгээр хуваарилагдсан.

Удаан эдэлгээт зүйлс, сууцны түрээс, сууцтай холбоотой үйлчилгээний зардлууд болон халаалт: Энэ бүрэлдэхүүн хэсэг нь нийтийн хэрэглээ учир өрхийн насанд хүрсэн зөвхөн эхний хүн дээр тооцогдоно.

Дээрх хэрэглээний бүрэлдэхүүн хэсэг бүрийн хувь хэмжээг тооцоолон ТХ-ийг дундажлан тооцох явдал нь сүүлийн шатны тооцоолол болно. Тооцооны дүнг хүн амын ялгаатай бүлгүүдээр *Хүснэгт 2*-т харуулав. Өрхийн насанд хүрсэн хамгийн эхний гишүүний хэрэглээтэй харьцуулан авч үзвэл насанд хүрсэн бусад гишүүд дунджаар тухайн хүний хэрэглээний 85%, хүүхдүүд 50-60%-ийг хэрэглэдэг байна.

Хүснэгт 2: Хэрэглээний төлвийн аргачлалаар тооцоологдсон тэнцвэржүүлэх хэмжээс

	Насанд хүрсэн эхний хүн	Насанд хүрсэн бусад гишүүд	Хүүхэд, 15-аас доош настай
Нийт өрхийн хувьд	1	0.84	0.51
Хэрэглээний эрэмбээр доод 40%-д байгаа өрхүүд	1	0.85	0.56
Хэрэглээний эрэмбээр доод 30%-д байгаа өрхүүд	1	0.85	0.56
Хэрэглээний эрэмбээр доод 20%-д байгаа өрхүүд	1	0.85	0.57
Хэрэглээний эрэмбээр доод 10%-д байгаа өрхүүд	1	0.84	0.57
Хэрэглээний эрэмбээр доод 5%-д байгаа өрхүүд	1	0.84	0.57

2. АМЬЖИРГААНЫ ТҮВШИНГЭЭР ТООЦОХ АРГАЧЛАЛ

Энэхүү тооцооллын үндсэн санаа нь дараах утгатай. Хэрвээ өрхийн ам бүлд өөр нэг нэмэлт гишүүн орж ирэхэд тухайн өрх өмнө нь байсан амьжиргааны түвшиндээ байхын тулд хэдий хэмжээний нэмэлт хэрэглээ хэрэгтэй болохыг тооцоолж байна гэсэн үг. Уг тооцоог хийхэд хэрэглээтэй эерэг хамааралтай гэж таамаглагдах амьжиргааны түвшинг хэмжих боломжит хувилбар шаардлагатай болдог. Ижил амьжиргааны түвшинд байхыг батлах зардлын түвшин бүрд ялгаатай байдлаар өрхийн илүү гишүүнд шаардлагатай нэмэлт зардал нь тооцогдоно. Өрх амьжиргааны нэг түвшингээс нөгөөд шилжихэд дээрх зардал өсөж, буурч, эсвэл тогтмол байж болно. Гэхдээ энэхүү тооцооллын хувьд өрхийн илүү гишүүнд хамааралтай уг нэмэлт зардал нь тогтмол хэмжээнд, хэрэглээний түвшингээс салангид тусдаа байна гэсэн таамаглал дээр үндэслэгдэж байгаа. Мөн хэрэглээ болон амьжиргааны түвшингийн хоорондох хамаарал нь шугаман байна гэж үзээд регрессийн стандарт загварыг хэрэглэж болно.

Ийм байдлаар амьжиргааны түвшинг хэмжих боломжит хувилбар нь хөрөнгийн индекс юм. Удаан эдэлгээт барааны өмчлөл болон сууцны зарим шинж чанарууд нь аж байдлыг орлуулан тооцох боломжтой нэг хэмжигдэхүүн гэсэн таамаглал дээр энэхүү тооцоолол үндэслэгддэг. Хөрөнгийн индекс нь хөргөгч; угаалгын машин; тоос сорогч; суудлын болон ачааны машин; харилцаа, холбоо, соёлын тоног төхөөрөмжүүд (зургийн болон дүрс бичлэгийн аппарат, дүрч бичлэгийн тоглуулагч гэх мэт зүйлүүдээс ядаж нэгийг өмчилдөг эсэх); төвлөрсөн усан хангамжинд холбогдсон эсэх; интернэттэй эсэх гэсэн үзүүлэлтүүдийг агуулсан. Хөрөнгийн индексийн авч байгаа оноо нь дээрх хөрөнгийн үзүүлэлтийн жигнэгдсэн нийлбэрээр тооцогдоно. Жин нь өрхийн өмчилж байгаа хөрөнгийн давтамжийн урвуу тоо байна.

Ялгаатай өрхүүдийн хувьд цаг хугацааны үе бүрд харьцуулагдсан тэнцвэржүүлэх ялгаатай хэмжээсүүдийг тооцож болно.

Регрессийн ерөнхий загвар дараах байдалтай байна:

$$\text{Liv_st_ind} = \beta_0 + \beta_1 \ln(\text{cons}) + \beta_2(\text{household type}) + \beta_3(\text{control variables}) + e$$

Энэ тохиолдолд,

Liv_st_ind -хөрөнгийн оноо

ln(cons) – нэг хүнд ноогдох хэрэглээний логирафм

household type –ялгаатай шинж чанар бүхий өрхүүдийг тодорхойлсон өрхийн төрлийг харуулах дамми хувьсагч

control variables –өрхийн суурьшил болон өрхийн тэргүүлэгчийн шинж чанар (жишээлбэл нас, хүйс, гэрлэсэн эсэх гэх мэт) зэргийг багтаасан хяналтын хувьсагч хэмжигдэхүүнүүд

Энэхүү тооцооллыг жишээгээр тайлбарлая. Өрхийн нэмэлт насанд хүрсэн хүнд зориулсан тэнцвэржүүлэх хэмжээс тооцох зорилготой байсан гэж үзье. Энэ үед өрхийн зөвхөн насанд хүрсэн гишүүдийн хувьд энэ тооцооллыг хийж болох бөгөөд өрхийн төрлийг харуулсан дамми хувьсагч нь насанд хүрсэн 2 гишүүнтэй, насанд хүрсэн 3 гишүүнтэй, насанд хүрсэн 4 гишүүнтэй өрх гэх мэтээр өөр өөр утга илэрхийлсэн хувьсагч байна. Насанд хүрсэн 1 гишүүнтэй өрхийг энэ тооцоонд оруулахгүй, жишиг категори болгож үлдээнэ. Насанд хүрсэн 1 хүнд хэрэгтэй нэмэлт зардлын эхний тооцоо нь насанд хүрсэн 2 гишүүнтэй өрхийг тодорхойлж байгаа хувьсах хэмжигдэхүүн болон хэрэглээг тодорхойлж байгаа хувьсах хэмжигдэхүүн тус бүрийн харгалзах коэффициентүүдийн харьцаагаар гарна. Хэрэглээний үзүүлэлт нь логирафмаар илэрхийлэгдэж байгаа учир уг харьцаа буюу бодит зардал нь дараах томъёогоор тооцогдоно.

$$\text{Нэмэлт гишүүний зардал} = \frac{\beta_2}{e^{\beta_1}}$$

Өрхийн илүү гишүүнд ноогдох нэмэлт зардлын тооцоонууд нь насанд хүрсэн 3 гишүүнтэй өрхийн хувьд, насанд хүрсэн 4 гишүүнтэй өрхийн хувьд гэх мэтээр тооцогдож болно. Гэхдээ өрхийн илүү гишүүн бүрд ноогдох дундаж нэмэлт зардлыг тооцохдоо өрхийн ам бүлийн харгалзах тоонд нь 3 эсвэл 4 гэх мэт хувааж тооцно.

Хүүхдийн нэмэлт зардлыг тооцоход мөн дээрхтэй адил тооцоог хийнэ. Дараах төрлийн багц тооцоо байж болно. Насанд хүрсэн 2 гишүүнтэй өрхийг жишиг категори болгож тооцооноос хасах ба өрхийн төрлийг харуулсан дамми хувьсагч нь насанд хүрсэн 2 гишүүнтэй болон 1 хүүхэдтэй, насанд хүрсэн 2 гишүүнтэй болон 2 хүүхэдтэй, насанд хүрсэн 2 гишүүнтэй болон 3 хүүхэдтэй гэх мэтээр өөр өөр утга илэрхийлсэн хувьсагч байна. Өөр нэг төрлийн багц тооцоо нь насанд хүрсэн 1 гишүүнтэй өрхийг жишиг категори болгож тооцооноос хасах ба өрхийн төрлийг харуулсан дамми хувьсагч нь насанд хүрсэн 1 гишүүнтэй болон 1 хүүхэдтэй, насанд хүрсэн 1 гишүүнтэй болон 2 хүүхэдтэй гэх мэтээр байж болно. Дээрх ялгаатай багц тооцоонуудаас гарсан насанд хүрсэн гишүүнд харгалзах нэмэлт зардлын дундаж утга нь өрхийн 1 дэх гишүүнтэй

харьцуулахад 0.7 - 0.8 гэсэн интервалд байна. Харин хүүхдэд харгалзах нэмэлт зардлын дундаж утга нь өрхийн 1 дэх гишүүнтэй харьцуулахад 0.5 - 0.6 гэсэн интервалд байна.

3. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЗАРДАЛ

Өрхийн ам бүлд хөгжлийн бэрхшээлтэй хүн байх нь нэмэлт зардал гарах нөхцлийг бий болгох магадлалтай. Хүн амын хэрэгцээг үнэлэх, ялангуяа хүн ам нийгмийн халамжийн ямар нэгэн үйлчилгээнд хамрагдах ёстой эсэхийг тодорхойлоход энэхүү зардлыг бодолцож үзэх нь гарцаагүй юм. Насанд хүрсэн хүн болон хүүхдэд хэрэглэгдэх тэнцвэржүүлэх хэмжээсийг тооцсон дээрх 2 аргачлал (хэрэглээний төлвөөр болон амьжиргааны түвшингээр)-ыг ашиглан хөгжлийн бэрхшээлтэй хүнд хэрэглэгдэх тэнцвэржүүлэх хэмжээсийг тооцож болно. Гэхдээ энэ шинжилгээг хөгжлийн бэрхшээлийн төрлөөр ялгаж хийх боломжгүй байсан гэдгийг сануулах нь зүйтэй. Учир нь түүврийн хэмжээ харьцангуй бага /нийт өрхийн 13% нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй гэж мэдээлсэн/ мөн хөгжлийн бэрхшээлийн зэргийг бүрэн үнэлэхэд бэрхшээлтэй байсан болно.

Хүснэгт 3: Хэрэглээний төлөв, хувиар, 2012

	Хөгжлийн бэрхшээлтэй хүн байхгүй өрх	Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй өрх
Нийт	100	100
Хүнс	40	41
Архи, тамхи	2	2
Хувцас	16	14
Боловсрол	4	4
Эрүүл мэнд	3	6
Халаалт	5	6
Үйлчилгээ	3	3
Тээвэр, холбоо	11	9
Бусад	8	8
Удаан эдэлгээт бараа	2	2
Түрээс	6	5

Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хамаарах зардлыг ялгаж тогтоох нь түвэгтэй байснаас болж хэрэглээний төлвөөр тооцох аргачлалыг бүрэн байдлаар нь хэрэглээгүй болно. Хөгжлийн бэрхшээлтэй ам бүлийн гишүүн бүхий өрх мөн хөгжлийн бэрхшээлтэй гишүүн байхгүй өрхүүдийн хэрэглээг харьцуулсан шинжилгээг эхний ээлжинд хийсэн. *Хүснэгт 3*-аас харахад хамгийн их ялгаа нь эрүүл мэндийн зардлын бүлэг дээр гарч байна.

Хөгжлийн бэрхшээлтэй нэг хүн өрхөд байхад л эрүүл мэндийн зардал нь хөгжлийн бэрхшээлтэй хүн байхгүй өрхтэй харьцуулахад 2 дахин их байна (6% болон 3%). Эрүүл мэндийн зардлыг хувь хэмжээгээр ингэж шууд хэлэх нь бас маргаантай. Учир нь эрүүл мэндийн зардал гаргасан өрхүүдийн амьжиргааны түвшин нь адилхан амьжиргаатай боловч эрүүл мэндийн зардал гаргаагүй өрхүүдийнхээс илүү өндөр гэж тодорхойлогдох болдог. Өрхийн хэн нэгэн өвчтэй байснаас болж эрүүл мэндийн зардал гаргасан өрхийг илүү чинээлэг өрх гэж тооцох нь утгагүй. Гэхдээ энэ тохиолдолд өрхийн амьжиргааны түвшин илүү байсан учраас зарим өрхүүд эрүүл мэнддээ зардал гаргаж чадсан, зарим өрхүүд амьжиргаа нь муу учраас эрүүл мэнддээ зардал гаргаж чадаагүй гэсэн таамаглал дээр үндэслэн дээрх аргачлалыг ашиглаж болно. Өрхөд байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүнд хамааралтай байх нэмэлт зардлыг тооцоход амьжиргааны түвшингээр тооцох аргачлал нь илүү зохимжтой байсан.

Нэмэлт зардал нь эрүүл мэндийн зардлын хувьд зөвхөн тооцогдох бөгөөд энэ зардал нь тусгай зориулалтын хувцас, тусгай тоноглол бүхий ор, угаалгын өрөө болон халаалтын илүү өндөр зардал гэх мэтийг багтаасан. Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй ижил амьжиргааны түвшинтэй байхын тулд хөгжлийн бэрхшээлтэй хүн нь илүү мөнгө зарцуулах хэрэгтэй байдаг гэж хэлж болох юм. Ийнхүү регрессийн өмнөх загвар нь хөгжлийн бэрхшээлтэй хүний зардалд илүү нийцсэн дараах байдлаар бичигдэж болно.

$$\text{Liv_st_ind} = \beta_0 + \beta_1 \ln(\text{cons}) + \beta_2(\text{disabled}) + \beta_3(\text{control variables}) + e$$

Энэ тохиолдолд,

disabled—өрхөд хөгжлийн бэрхшээлтэй хүн байгаа эсэхийг харуулах дамми хувьсагч

Насанд хүрсэн хүн болон хүүхдэд хэрэглэгдэх тэнцвэржүүлэх хэмжээсийг тооцсонтой адил арга замаар хөгжлийн бэрхшээлтэй хүнд шаардлагатай нэмэлт зардал тооцогдоно. Тооцооллын үр дүнгээс харахад хөгжлийн бэрхшээлтэй хүний хувьд тэнцвэржүүлэх хэмжээс нь 1.3 болон 1.4 гэсэн интервалд байна.

ДҮГНЭЛТ

Олон улсын стандарт хэмжээсүүдийг судалж үзэх нь тэнцвэржүүлэх хэмжээс тооцох сүүлийн үйл ажиллагаа байсан.

Нэгдүгээрт, Эдийн засгийн Хамтын ажиллагаа, Хөгжлийн Байгууллага (ЭЗХАХБ)-ын гишүүн орнуудын хувьд дараах тэнцвэржүүлэх хэмжээсийг, өрхийн насанд хүрсэн эхний гишүүнд 1, насанд хүрсэн бусад гишүүдэд 0.7, хүүхдэд 0.5 гэсэн коэффициентийг хэрэглэдэг байсан. Энэхүү коэффициентийг одоогоор Зөвлөлт Холбоот Улсын бүрэлдэхүүнд байсан орнууд, мөн шилжилтийн эдийн засагтай байгаа улс орнууд голдуу хэрэглэж байна.

Хоёрдугаарт, хүүхдэд холбогдох зардал бага байдаг, нийтийн бараа үйлчилгээ/дундын хэрэглээний, ялангуяа сууцны ач холбогдол өсөн нэмэгдэж байгаа зэргийг харгалзан ЭЗХАХБ нь дээрх коэффициентийг өөрчлөн сайжруулсан. Шинэчилсэн тооцоогоор тэнцвэржүүлэх хэмжээс нь өрхийн насанд хүрсэн эхний гишүүнд 1, насанд хүрсэн бусад гишүүдэд 0.5, хүүхдэд 0.3 гэсэн коэффициентийг оноож байна.

Олон улсад түгээмэл хэрэглэгддэг гурав дах тэнцвэржүүлэх хэмжээс нь Дэлхийн банкнаас зүүн Европи, төв Азийн орнуудад хэрэглэдэг коэффициент юм. Энэ нь өрхийн

ам бүлийн тоог 0.75 зэргээр (өрхийн ам бүлийн тоо^{0.75}) өсгөн тооцсон тооцоо бөгөөд ЭЗХАХБ-ын анхны/хуучин коэффициенттэй ойролцоо тоон утгыг илэрхийлсэн байдаг.

Хэрэглээний төлвөөр болон амьжиргааны түвшингээр тэнцвэржүүлэх хэмжээсийг тооцох өмнө тайлбарласан аргачлалуудын үр дүн нь нь өрхийн насанд хүрсэн эхний гишүүнээс бусад гишүүдийн хувьд 0.7-0.85, хүүхдийн хувьд 0.5-0.6 гэсэн коэффициент байж болохыг харуулж байна. Эдгээр тоон утгууд нь ЭЗХАХБ-ын хуучин коэффициенттэй төсөөтэй утга илэрхийлж байна. Монгол Улсын хөрш зэргэлдээ орнууд болон хөгжлийн ойролцоо түвшинд байгаа улс орнууд ЭЗХАХБ -ын энэ хуучин коэффициентийг хэрэглэж байгаа учир тооцооны энэ үр дүнг нийцтэй байна гэж хэлж болно. Иймээс ЭЗХАХБ -ын хуучин коэффициентийг буюу өрхийн насанд хүрсэн эхний гишүүнд 1, насанд хүрсэн бусад гишүүдэд 0.7, хүүхдэд 0.5 гэсэн коэффициентийг Монгол Улсад

тэнцвэржүүлэх хэмжээсээр ашиглах бүрэн боломжтой гэж үзэж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хувьд тухайн фактор нь 40 хувиар өсөх бөгөөд, өрхийн насанд хүрсэн эхний гишүүн бол 1.4, өрхийн насанд хүрсэн бусад гишүүн 0.98 ($=0.7*1.4$), хүүхэд бол 0,7 ($=0.5*1.4$) гэсэн коэффициентийг ашиглана.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Peter Lanjouw, Branko Milanovic and Stefano Paternostro (1998), *Poverty and Economic Transition: How Do Changes in Economies of Scale Affect Poverty Rates of Different Households?*

Asghar Zaidi and Tania Burchardt (2005), *Review of Income and Wealth, Series 51, Number 1, Comparing incomes when needs differ: Equivalization for the extra costs of disability in the UK*